

**ОРОС БОЛОН ӨРНӨ ДАХИНД ОЙРАД, ХАЛИМАГИЙН АМАН ҮЛГЭРИЙГ
ЦУГЛУУЛАН ЭМХЭТГЭЖ ХЭВЛҮҮЛСЭН ТҮҮХЭН ТОЙМ**

Балжаан Дамиранжав

Ойрад болон халимагууд нь БНХАУ-ын ШУӨЗО, Хөхнуур, Ганьсу муж болон ӨМӨЗО-ы Алшаа, Хөлөнбуйр, Шилийнгол аймгаар аж төрөн суудаг. Зөвхөн Цахар нутагт гэхэд нийт 24 сум ойрад хүмүүс байна. Үүнээс гадна Хармөрөн мужийн Чичигар болон Хэбэй мужийн Чэндэ зэрэг газар оронд нэлээд тооны ойрад хүмүүс аж төрж байна. Мөн Монгол улсын Ховд, Увс, Баян-Өлгий, Хөвсгөл, Завхан зэрэг аймгуудаар амьдран суухаас гадна Говь-Алтай, Архангай, Баянхонгор зэрэг аймагт бас бий.

ОХУ-д гол төлөв БНХалимаг Улсад төвлөрөн суухаас гадна Астрахань болон бусад мужаар тархан суурьшин амьдарч байна. Түүнчлэн Киргиз, Хасаг, Америкт ойрад, халимаг хүмүүс амьдарч байгаа ба Франц, Чех, Словак зэрэг Европын улс орноор цөөн тооны ойрад хүмүүс суурьшин сууж байна.

Эдүгээ болтол БНХАУ, Монгол улс болон ОХУ-д амьдарч байгаа торгууд, дөрвөд, өөлд, хошууд, баяд, урианхай, захчин, мянгад, хойд зэрэг ойрад хүмүүсээс эрдэмтэн судлаачид нэгэнт цуглуулж авсан буюу хэвлүүлсэн аман үлгэрүүдийг тооцон үзвэл 5000 гаруй, бүгд хэвлүүлсэн аман үлгэрийн ном дэвтэр 300 гаруй хүрч байна. Үүний дотор 400 гаруй баатарлаг үлгэр байгаа юм.

Ойрад хүмүүс нь эртнээс аваад аман зохиолын өв уламжлалаар асар баялаг уламжлалтай билээ. Тухайлбал “Жангар”, Гэсэр”, “Хан Харангуй” мэт баатарлаг тууль болон бусад аман зохиол, аман үлгэрүүд нь үе үеийн жангарч, гэсэрч, туульч болон үлгэрч нарын амаар дамжин олон зуун жил уламжлагдан ирэхдээ аман болон судар бичгийн хэлбэрээр тэмдэглэгдэж ирсэн түүхтэй. Ийм ч учраас ойрад, халимаг үлгэрийг багтаасан аман зохиол нь Орос, Халимагийн эрдэмтэн болон Герман, Унгар, Финленд, Польш, Латви, Чех зэрэг өрнийн эрдэмтэн судлаачид хийгээд тусгаар улс үндэстний эрдэмтний анхаарлыг аль эртнээс ихэд татаж байсан ба ойрад, халимагийн аман зохиолыг сурвалжлан цуглуулах, орчуулах, эмхэтгэн хэвлүүлэх ажил нь XVIII зууны дунд үеэс эхэлсэн байна. Жишээ нь:

1768-1769 онд Оросын судлаач И.И.Лепехин халимаг нутгаар хээрийн шинжилгээ хийж байхдаа нэлээд олон аман үлгэр олж цуглуулжээ. Улмаар түүнийгээ оросоор орчуулсан байна [1]. Мөн Герман эрдэмтэн Петер Симон Паллас Хаант Оросын Академид уригдан ирж ажиллаж байхдаа XVIII зууны дундуур халимаг нутгаар хээрийн шинжилгээ хийжээ. Тухайн үедээ тэр тэндээс хэдэн ардын дуу тэмдэглэж авсан бөгөөд мөн халимаг нутагт халимаг хүмүүс товшуур, цуур, ихэл, бийв, аман хуур мэт зүйл бүрийн хөгжмийн зэмсэг хэрэглэж дуу дуулж, бий бийлж (биелгээ хийж) байсан ба бас үлгэр тууль хэлж, “Жангар” хайлж байсан

тухай занги чимээг маш нарийнаар тэмдэглэсэн байдаг [2]. Мөн түүнчлэн “Гэсэр”-ийн тухай сураг зангийг ч тэмдэглэсэн нь бий.

Энэ цагаас хойш ойрад, халимагийн аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг цуглуулах, орчуулах, чухам эрдэм шинжилгээний үүднээс тэмдэглэн авч нийтлүүлж, олны хүртээл болгох ажил Б.Бергман, А.А.Бобровников, Н.И.Михайлов, А.Попов, И.Я.Шмидт, К.Ф.Голстунский, Габор Балинт, А.М.Позднеев, И.И.Попов, Б.Юльг, Г.Гомбоев, Лерош, Лер, Г.Н.Потанин, А.Бадмаев, Г.Й.Рамстедт, В.Л.Котвич, Б.Я.Владимирцов, А.В.Бурдуков, Очирын Номт (Очра Номт), Басангийн Баатар (Басңа Баатр), Номынханы Цэрэндорж (Номинхана Церндорж) зэрэг нэрт эрдэмтэн судлаачид чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Халимаг үлгэрийн хамгийн анхны ном хэвлэлийг гаргасан хүн бол Б.Бергман юм. Тэрээр 1772 онд Лифланд буюу одоогийн Латви улсад төрсөн хүн байв. Б.Бергман Германы Лейпциг хотод их сургууль төгссөн бөгөөд шашны хувраг байжээ. Тэрээр 1802 онд Сарептад ирж амьдарсан ба энэ газар нь одоогийн Оросын Холбооны Улсын Волгоград хот юм. Энэ нутаг нь Халимагийн нутагтай ихэд ойрхон аж. Тийм ч учраас Б.Бергман 1802-1803 онд Халимаг нутагт сууж халимаг хэл тун сайн сурчээ. Улмаар Халимагийн нутгаар хээрийн шинжилгээ хийж, аман зохиолын баялаг хэрэглэгдэхүүн цуглуулсан байна. Энэхүү цуглуулгаа герман хэлээр орчуулан дөрвөн боть болгон 1804, 1805 онд “1802-1803 онд халимагуудын дунд нүүдэллэн хэсүүчилсэн нь” хэмээх нэрээр Рига хотод хэвлүүлсэн байна [3]. Эдгээр бүтээлд халимагуудын зан үйл болон “Жангар”, “Гэсэр”, “Шидэт хүүрийн үлгэр” зэрэг олон эх аман зохиол орсон ба эл бүтээлийг хожим Европын олон хэлээр орчуулан хэвлүүлсэн нь ойрад, халимагийн соёл болон “Жангар” тууль дэлхий дахины олон хүний чихэнд дуурсаж, олон нийтэд мэдэгдэж, алдарших үндэс нь болсноороо чухал ач холбогдлыг үзүүлсэн юм [4].

Халимаг ойрадын аман үлгэр, аман зохиолын зүйлийг монгол хэл, тод үсгээр хэвлүүлсэн хүн бол нэрт эрдэмтэн, профессор К.Ф.Голстунский юм. Тэрээр 1864 онд “Убаши хун тайжийн тууж”-ийг бүтнээр, “Жангар”-ын туульсаас “Шар Гүргүүгийн бүлэг”, бас нэр нь үл мэдэгдэх нэг бүлэг, мөн 12 цуврал үлгэр бүхий “Шидэт хүүрийн үлгэр” байна.

1866 онд Германы эрдэмтэн Б.Юльг Лейпциг хотод “Халимаг аман үлгэр” [6] хэмээх бүтээл хэвлүүлжээ. Уг бүтээлд “Шидэт хүүрийн үлгэр”-ийн хэдэн үлгэрийг тод үсгээр болон герман хэлний орчуулгатайгаар нийтэлсэн байна. Мөн 1868 онд “Шидэт хүүрийн үлгэр”-ийн хэдэн үлгэрийг германаар орчуулан хэвлүүлжээ [7].

Санкт-Петербургийн Их сургуулийн Дорно дахины салбарын монгол хэл болон төвд хэлний багш, эрдэмтэн Г.Гомбоев (Гомбын Галсан) “Шидэт хүүрийн үлгэр”-ийн 12 үлгэрийг 1864 онд тод үсгээр хэвлүүлсний хамт түүнийгээ орос хэлээр орчуулан хэвлүүлсэн байна [8].

1873 онд эрдэмтэн Лер “Халимагийн аман үлгэр” [9] гэсэн нэгэн номыг Москва хотод хэвлүүлжээ. Энэ эмхэтгэлд Халимагийн нэлээд хэдэн үлгэрийг оросоор орчуулсан байна.

Халимаг ойрадын аман үлгэрийг XVIII зууны дундаас эхлэн цуглуулах, тэмдэглэх, орчуулах, хэвлүүлэх ажилд Орос болон Германы эрдэмтэд асар их хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ. Гэхдээ халимаг, ойрадын баатарлаг үлгэрийг цуглуулах, тэмдэглэх ажлыг хамгийн анх хийсэн хүн бол Унгарын хэл судлаач, нэрт эрдэмтэн Габор Балинтыг юуны урьд дурдах чухалтай байна. Тэрээр 1872 оны эцэс болон 1873 оны эхээр монгол хэл судлах зорилгоор Оросын халимаг нутагт хээрийн шинжилгээний хэдэн сарын аялал хийсэн байна. Ингэхдээ урьдаар Казанийн Их сургуульд очиж, тэнд суралцаж багшилж байгаа халимаг багш оюутныг сурвалжлан, дахин халимаг нутагт хүрч хэдэн сар хээрийн шинжилгээ хийж нэлээд олон судалгааны эх хэрэглэгдэхүүнийг олсон бөгөөд энэхүү эх хэрэглэгдэхүүндээ халимагуудын өдөр тутмын ярилцааны материалаас гадна, халимагуудын тухайн цаг үед гүйцэтгэж байсан

зүйл бүрийн зан үйлийн болон аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний латин галиг үсгээр тэмдэглэж авсан байна. Тэрхүү материал нь 140 гаруй жил Унгарын ШУА-ийн архивт хадгалагдсаар ирсэн бөгөөд 2011 онд Унгарын ШУА болон Оросын ШУА-ийн Халимагийн соёл тууж шинжилгээний хүрээлэн хамтран гэрэл зургаар буулган “XIX зууны дунд үеийн Халимагийн зан үйл хийгээд ардын соёл” [10] нэрээр Будапешт хотод хэвлүүлж олны хүртээл болгосон байна. Тус эмхэтгэлд Габор Балинтын халимаг нутгаас цуглуулсан зан үйлийн элдэв зүйлийн материалаас гадна ерөөл, ардын дуу, үлгэр [11], тайллагатай тууль [12], ут тууль [13] зэрэг халимаг ардын аман зохиолын олон төрөл зүйлийн эх хэрэглэгдэхүүн орсон байна. Ут тууль гэсэн аман үлгэрийн дотор “Богширго” гэсэн нэгэн амьтны үлгэр, “Могой дүртэй хөвүүн”, “Тарваж хаан”, “Улаадай мэргэн ба чоно, баавгай” зэрэг долоон шидэт үлгэр болон “Зул шар Арслан баатар”, “Өнчин хөвүүн”, “Чулуун хар баатар”, “Жаргалчин улаан хацар”, “Хэцүү бэрх баатар” гэсэн таван баатарлаг үлгэр, нийт 15 үлгэрийг тэмдэглэсэн байна.

Ойрад халимагийн аман зохиол, зан үйлийн хэрэглэгдэхүүнийг цуглуулах, хэвлүүлэх талаар Г.Н.Потанин багагүй хувь нэмэр оруулжээ. Тэрээр 1876-1877 болон 1879-1880 онд Монголын баруун хэсгээр жуулчлан явахдаа аман үлгэр, домог үлгэр, домог болон ардын дууны арвин материал цуглуулж “Баруун хойд Монгол” [14] гэсэн дөрвөн боть зохиолоо 1881-1883 онд нийтлүүлсэн байна. Эл дөрвөн боть зохиолын хоёр болон дөрөвдүгээр боть нь ойрадын зан заншил, аман зохиолтой холбоотой зүйлс оржээ. Хоёр зуу гаруй үлгэрийг оросоор товч орчуулсан ба эдгээр үлгэрүүд эдүгээ бараг мартагдсан байна. Үүний дотор баатарлаг үлгэр хэд хэд байна. Харин хоёрдугаар ботийг нь Японы Зүүн Азийг судлах хүрээлэнгээс япон хэлээр орчуулан 1945 онд хэвлүүлжээ [15]. 2013 онд Ланжуугийн Их сургуулийн хэвлэлийн хорооноос Г.Н.Потанины Монголоор жуулчилсан хэсгийг нь хятад хэлээр орчуулан “Монголоор аялсан нь” гэх нэрээр хэвлүүлжээ [16].

Эрдэмтэн А.М.Позднеев Ойрад, Халимагийн түүх [17], аман зохиол болон “Жангар” [18], монгол ардын дуу [19] зэргийг цуглуулж хэвлүүлэх талаар гарамгай амжилт гаргасан эрдэмтний нэг юм. Тэрээр Петербургийн Их Сургуулийн Дорно дахины салбарын даалгавраар олон удаа халимагаар явжээ. Ийн явахдаа цуглуулсан хэрэглэгдэхүүнээ эмхэтгэж 1880-1915 оны хооронд олон ном хэвлүүлсэн байна. 1886 онд Санкт-Петербургт “Халимаг ардын үлгэр-халимаг эх бичвэр (текст)-ээр хэвлүүлсэн А.Позднеев” [20] гэсэн номоо тод үсгээр чулуун бараар хэвлүүлсэн байна. Энэ номонд “Алтан өргөжих хааны нутагт байдаг мөнгөн өргөжих баяны хөвүүн, Манжийн Зарлиг ялч хөвүүн хоёрын тууль”, “Баян хүний арван долоотойн тууль” зэрэг дөрвөн шидэт үлгэр болон “Баг сахал Байдай мэргэн хааны хөвүүн, Харц мэргэний тууль” гэсэн нэг баатарлаг үлгэр оржээ.

1889-1897 оны хооронд “Эзэн хааны Оросын Археологийн нийгэмлэгийн Дорно дахины салбарын эрдэм шинжилгээний бичиг” [21] гэсэн номонд 10 үлгэрийг тод үсгээр чулуун бараар хэвлүүлж гаргасан байна. Тус 10 үлгэрт “Гэсэр”-ийн нэг үлгэр орсон бөгөөд мөн нэг баатарлаг үлгэр хэвлэгджээ.

1892 онд нэг баатарлаг үлгэр болон таван шидэт үлгэрийг “Астрахань мужийн Халимагийн тал нутгаас цуглуулсан Халимаг ардын үлгэрийн жинхэнэ халимаг эх бичвэр (текст)-ээр” [22] гэсэн номоо тод үсгээр чулуун бараар хэвлүүлсэн байна. Үүнээс гадна монгол ардын дуу, ойрад халимагийн түүх, бичгийн уран зохиолын олон ном хэвлүүлсэн авьяас чадвартай, алдартай эрдэмтэн байсан юм.

Ойрад, халимагийн аман зохиолын судлалд тэмдэглэх ёстой дараагийн хүн бол И.И.Попов юм. Тэрээр багаасаа халимагуудтай хамт Тэн (Дон) мөрний хавиар аж төрж байхдаа халимаг хэл, тод үсгийг сайн сурчээ. Ялангуяа халимагуудын хэлдэг аман зохиолд сонирхолтой болж,

тэдний дунд яригдаж байсан аман зохиолын олон төрлийг 1890-1893 оны хооронд тод үсгээр тэмдэглэж, орос маягийн кирил галиг үсгээр давхар галиглан, орос орчуулгыг хадаж өгчээ. Энэхүү эрдэм шинжилгээний хэрэглэгдэхүүн нь эдүгээ Ростов мужийн архивт хадгалагдаж байна. Үүнд нэгэн зүйлийг онцлон дурдахад, тэрээр энэхүү гар бичмэлийн ботиудад орсон эх хэрэглэгдэхүүнээ дэлгэрэнгүй тайлбартай үйлдэж, мөн тайлбар бүхий бичгийг хавсаргаж өгсөн нь эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй ажил болсон байна. И.И.Поповын гар бичмэл, эх хэрэглэгдэхүүнд нь “Жангар” [23], 367 оньсого бүхий “Тэн голын халимагуудын тайлбартай туульс” [24], 186 зүйр цэцэн үг бүхий “Тэн голын халимагуудын үлгэрүүд” [25]-ээс гадна явган үлгэр, домог үлгэр, домгийг тэмдэглэсэн гурван боть гар бичмэл байхаар үл барам мөн тусгаар бичгийн зохиолыг тэмдэглэж орчуулсан зүйлс ч нэлээд байна.

И.И.Поповын 1890-1892 онд тэмдэглэсэн 13805 тоот архивын дугаар бүхий “Тэн голын халимагуудын туульс” [26] хэмээх гар бичмэлийн ботид нийт 42 явган үлгэр орсон байна. Үүнээс баатарлаг үлгэр 6, шидэт үлгэр 19, аж байдлын үлгэр 12, амьтны үлгэр 4, домог 1 байна. Архивын 13810 тоот хавтаст “Тэн голын халимагуудын аман үлгэр” (1892 оны гар бичмэл) [27] байх ба 2 баатарлаг үлгэр, 5 шидэт үлгэр, 2 аж байдлын үлгэр байна. Архивын 13809 дугаарт “Халимагуудын хэлсэн туужийг хураан бичсэн нь оршвой” (1892 оны гар бичмэл) [28] хэмээх ботид нийт 19 үлгэр, үүний олонх нь домог байна. Мөн 1 домог үлгэр, 9 домог, 6 амьтны үлгэр, 3 аж байдлын үлгэр орсон байна. И.И.Попов 1938 онд 1890-1893 оны хооронд цуглуулж тэмдэглэсэн үлгэрүүдээсээ 15 үлгэрийг сонгон “Дон голын халимагуудын аман үлгэр” [29] гэсэн эмхэтгэлээ орос хэлээр Ростов хотод хэвлүүлсэн юм.

1899 онд А.Бадмаев Халимагийн 27 үлгэрийг орос хэлээр орчуулан “Халимагийн аман үлгэрийн эмхэтгэл” [30] гэсэн нэрээр Астраханьд хэвлүүлсэн байна. Гэхдээ тус эмхэтгэлд орсон үлгэрийг хэдийд хаанаас тэмдэглэж авсан мэдээ сэлтгүйгээр хэвлүүлсэн нь түүний эрдэм шинжилгээний үнэ цэнийг зохих хэмжээгээр бууруулсан байна.

1909 болон 1919 онд Финляндын нэрт эрдэмтэн Г.Рамстедт 1902 онд Халимагийн нутгаар хээрийн шинжилгээ хийж олсон эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлан эрдэм шинжилгээний галиг үсэг болон герман орчуулгатайгаар “Халимагийн аман үлгэр” гэх хоёр ном [31]-оо Финландын нийслэл Хельсинкт хэвлүүлжээ. 1909 онд хэвлүүлсэн номонд 18 үлгэр орсны гурав нь баатарлаг үлгэр, долоон шидэт үлгэр, гурван аж байдлын үлгэр, дөрвөн хошин шог үлгэр байна. 1919 онд хэвлэгдсэн номонд нь баатарлаг үлгэр гурав, шидэт үлгэр нэг байна. Мөн энэхүү хоёр номыг нийлүүлж 2008 онд Хельсинкт дахин хэвлүүлжээ. Г.Рамстедт халимаг, ойрадын нутгаас аман зохиолын олон төрөл зүйлийг цуглуулсан юм. Тэрээр хээрийн шинжилгээгээр олсон эх хэрэглэгдэхүүнээ олон улсын галиг болон герман орчуулгатай хэвлүүлж байсан зүйлс нь өнөөдөр манайд хэрэглэхэд эрдэм шинжилгээний маш өндөр үнэ цэн бүхий судалгааны ховор нандин хэрэглэгдэхүүн болсон байна.

Ойрад, халимагийн аман зохиолыг цуглуулах судлах талаар үлэмж хувь нэмэр оруулсан хүн бол алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов юм. Тэрээр “Панчатантраас авсан монгол үлгэрийн поморлиг” (1921), “Монгол ойрадын баатарлаг тууль” (1923), “Монгол ойрадын аман зохиолын жишээ” (1926) гэх номуудыг хэвлүүлж байсан билээ. 1923 онд Б.Я.Владимирцов тод үсгээс орос хэлэнд орчуулан 24 үлгэр бүхий “Шидэт хүүрийн үлгэр” [32]-ийг Москва хотод хэвлүүлсэн бөгөөд 1958 онд дахин хэвлэжээ. 1962 онд Э.Г.Манжиевээс энэхүү “Шидэт хүүрийн үлгэр”-ийн 24 үлгэрийг халимаг хэлэнд орчуулан “Үхсэн цогцын хувилгаан-Монгол Ойрадын туульс” [33] гэсэн нэрээр халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн байна.

XVIII зуун болон XIX зууны ойрад халимагийн аман зохиолыг сурвалжлан цуглуулах, тэмдэглэх, орчуулах, хэвлүүлэх ажлыг голдуу Орос болон Өрнийн эрдэмтэн судлаачаас

гүйцэтгэж байсан бол харин XX зууны эхнээс эхлэн халимагийн эрдэмтдээс өөрийнхөө аман зохиол, соёлоо сурвалжлан цуглуулах, тэмдэглэх, орчуулах, хэвлүүлэх ажил үйлсэд идэвхийлэн оролцож эрчимтэй ажиллаж эхэлсэн байна. Үүнд нэрт алдарт эрдэмтэн Очирын Номт [34], Баасангийн Баатар мэтийн хүмүүсийг дурдаж болох юм.

XX зууны эхэн үе Халимагийн аман зохиолын олон төрөл зүйл болон “жангар”-ыг сурвалжлан цуглуулах ажилд гарамгай гавьяа зүтгэл үзүүлсэн хүний нэг нь нэрт эрдэмтэн Очирын Номт юм. Тэр бол нэрт эрдэмтэн В.Л.Котвичийн шавь байсан бөгөөд Петербургийн Их Сургууль болон багшийнхаа даалгавраар халимаг аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг цуглуулан тэмдэглэх, хуучны гар бичмэлийг эрж сурвалжлах зорилгоор Халимагт олон удаа явсан билээ. Тэрээр 1908 онд Халимагт очиж алдарт жангарч Ээлэйн Овлаа (Ээлэн Овла)-аар арван бүлэг “Жангар” хайлуулан, эрдэм шинжилгээний орос галиг үсгээр тэмдэглэж авсан бөгөөд түүнийг нь багш В.Л.Котвич нь тод үсгээр буулган 1910 онд “Тахь зул хааны үлдэл Тансаг бумба хааны ач Үйзэн алдар хааны хөвүүн үеийн өнчин Жангарын арван бүлэг” [35] гэсэн нэрээр Петербург хотод хэвлүүлсэн билээ. Мөн 1909-1911 оны хооронд Астраханед олон удаа очиж, тэндэхийн дөрвөд, торгууд хүмүүсээс баатарлаг тууль, явган үлгэр, ардын дуу, домог үлгэр, домог, зүйр цэцэн үг болон оньсого зэрэг олон арвин материалыг эрдэм шинжилгээний орос галиг үсгээр тэмдэглэж авчээ. Түүний цуглуулга эдүгээ ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн архивт гар бичмэл эхээр хадгалагдаж байна.

2006 онд Оросын ШУА-ийн Халимагийн соёл түүхийн шинжилгээний хүрээлэнгийн судлаач доктор (Sc.D) Б.А.Бичеевээс Очирын Номтын 1909-1911 онд Айдарханийн дөрвөд, торгуудаас цуглуулсан аман зохиолын материалуудыг эмхэтгэж “Мөнхийн дээж-аман уран үгийн зохиолуудаас” [36] гэсэн нэрээр Элстэй хотод халимаг кирил үсгээр хэвлүүлсэн юм. Тус ном нь эрдэм шинжилгээний томоохон удиртгалтай, мөн аман зохиол нь дотроо дөрвөд, торгуудын гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна. Дөрвөдийн хэсэгт нь хоёр шидэт үлгэр, таван аж байдлын үлгэр, нэг амьтны үлгэр, 18 домог болон 132 цэцэн үг, 135 оньсого болон 59 ардын дуу оржээ. Торгуудын хэсэгт нь хэдэн ерөөл, 22 дуунаас гадна хоёр баатарлаг тууль, дөрвөн шидэт үлгэр, хоёр амьтны үлгэр, гурван домог орсон байна. Эмхэтгэлийн хойно нь үлгэр болгоны ерөнхий агуулгыг нь оросоор орчуулсан ба зарим нэгэн түүхийн учрыг маш нарийн тайлбарласан байна. Дуу бүрийн учир утгыг орос хэлээр тун ойлгомжтой тайлбарлаж өгчээ. Бас нэрийн хэлхээс, үгсийн тайлбар толийг үйлдэж өгсөн байна.

Чех улсад ажиллаж амьдарч байсан халимаг эрдэмтдээс халимагийн түүх, соёлын томоохон чуулган болох “Хонх-халимагийн дээж бичиг” [37] гэсэн 5 боть номыг тод үсгээр 1925-1927 оны хооронд хэвлүүлж, үүндээ “Жангар”, “Гэсэр”, “Шидэт хүүрийн үлгэр”-ээс гадна жаран хэдэн аман үлгэр хэвлэсэн байна. Энэхүү “Шидэт хүүрийн үлгэр” нь дотроо мөн бас 12 цуврал үлгэртэй буюу. Энэхүү явдал нь тухайн үеийн халимаг үлгэрийг судлахад чухал гарын авлага болж байв. Тус таван ботид хэвлэгдсэн аман үлгэрийн олонх нь амьтны үлгэр байсан бөгөөд үүнд “Турван хөвүүнтэй эмгэн өвгөн хоёр”, “Бүгүнэйн хөвүүн гунан настай бүргэд” гэдэг хоёр баатарлаг үлгэр орсон байна.

Халимагийн эрдэмтэн судлаачдаас 1929, 1933 болон 1936 онд Халимаг нутагт халимаг хэл ба аман зохиолын тухай гурван удаагийн эрдэм шинжилгээний хээрийн шинжилгээ хийсэн байна. Энэ удаагийн хээрийн шинжилгээгээр судлаачид Халимаг нутгаас маш олон ардын дуу, зүйр цэцэн үг, оньсого, явган үлгэр, домог үлгэр, домгийг цуглуулж авсан бөгөөд энэхүү хэрэглэгдэхүүндээ суурилад “Халимаг явган үлгэр” [38] номыг И.И.Кравченко 1936 онд орос хэлээр Сталинград хотод хэвлүүлжээ. Тэрээр 1940 онд “Халимаг ардын аман зохиол” [39] гэсэн номоо Элстэй хотод орос хэлээр хэвлүүлсэн байна.

Халимаг нутагт олон жилийн турш хэвлэгдсэн ном дэвтрийн дотроос хамгийн алдартай нь 1941 онд хэвлүүлсэн “Халимаг фольклор” [40] юм. Энэ ном нь эрдэмтдийн 1929, 1933 болон 1936 онд халимаг нутаг дэвсгэр дээр хийсэн хээрийн шинжилгээний материал болон 1935 онд Элстэй хотод болсон ардын авъяастны уралдаан тэмцээний үеэр тэднээс тэмдэглэж авсан аман зохиолын эх хэрэглэгдэхүүнд тулгуурласан байна. Тус номыг эрдэмтэн Лежийн Цэрэн (Лежин Церн), Шалварын Гарай (Шалврин Ёэрэ) нар эрхлэн хэвлүүлжээ. Үүнд ардын дуу, ерөөл, тууль, ут тууль болон аман зохиолын бусад төрөл зүйлийг багтаасан томоохон бүтээл орсон байна. Жишээ нь, дууны бүлэгт 71 дуу орсон бөгөөд түүнийгээ долоон хэсэгт хуваасан байна. Ерөөлийн бүлгээ хуучин ба шинэ ерөөл гэж хоёр хуваасан бөгөөд түүнд нэлээд олон ерөөл оржээ. Эпос (тууль гэсэн утга бүхий орос үг)-ийн бүлэгт найман бүлэг “жангар” оржээ. Мөн дом шившлэгийн үгс, оньсогууд, зүйр цэцэн үгс зэргийг оруулсан байна. Ут туулийн бүлэгт шидэт тууль, баатарлаг тууль, адгуусан амьтны тууль, нийгмийн болон ахуй байдлын тууль, домог зэргийг оруулсан байна.

Тус эмхэтгэлийн хамгийн гол ач холбогдол нь эмхэтгэгчээс олон удаагийн хээрийн шинжилгээгээр олж цуглуулсан аман зохиолоо огт засалгүйгээр буулгасан, ойрад халимагийн аман зохиолыг шинжлэх ухаанчаар анх удаа маш нарийнаар төрөл зүйлд хуваан бичсэнд оршино. Мөн төгсгөлд нь уг бүтээлд орсон аман зохиол болгоныхоо хэлсэн хүн, түүний нас жил, түүнийг тэмдэглэсэн он жил сар өдөр, газар орон, тэмдэглэгч гэгч зүйлийг маш нарийнаар гаргаж өгсөн байна. Ингэж үйлдсэн зүйл нь өнөөдөр хүртэл манай аман зохиолыг яаж цуглуулах, хэрхэн төрөл зүйлд хуваах, тайлбарлах зэрэг зүйлсэд үйлдэх жишээ болох бодит баримт болсноор ач холбогдолтой юм.

Дэлхийн II дайн болон халимагуудыг Сибирь рүү нүүлгэн шилжүүлж цөлсөн явдал нь Халимагийн аман зохиолын цуглуулга, судалгаанд олон жилээр тасалдах нөхцөл болсон байна. 1957 онд Халимагийн аман зохиолыг цуглуулах, судлах ажил дахин сэргэж, эрдэмтэн судлаачдаас олон үлгэрчдийг сурвалжлан тэмдэглэх ажил эрчимтэй хийгдэж ирсэн бөгөөд үүний үр дүнд тухайлбал “Сэтгэлийн хүүр” (1960), “Халимаг тууль” (нэг, 1961), “Халимаг тууль” (хоёр, 1968), “Халимаг аман үлгэр” (1959 он, Б.У.Жимбинов, орос хэлээр), “Халимаг аман үлгэр” (1962 он, Б.У.Жимбинов, орос хэлээр), “Халимаг аман үлгэр” (1962 он, С.Д.Алексеев, Л.Сангаев, орос хэлээр), “Халимаг аман үлгэр” (1962 он, Н.К.Илишкин, орос хэлээр), “Зэс үстэй хүүхэн – Халимаг аман үлгэр” (1964 он, М.Ватагин, орос хэлээр) гэх мэтийн халимаг аман үлгэрүүд болон бусад төрлийн аман зохиолын эмхэтгэлүүд ч олноор хэвлэгдэж эхэлсэн байна.

1960 онд Бурина Муутлараас тэмдэглэж авсан “Шидэт хүүрийн үлгэр”-ээ Букшаан Бадмаас “Сэтгэлийн хүүр” [41] (Сэтгэлийн хүүрнэл, сэтгэлийн яриа гэсэн утга бүхий ойрад халимаг аялгууны үгс) гэсэн нэрээр Элстэй хотод халимаг кирил үсгээр хэвлэжээ.

Оросын ШУА-ийн Халимаг хэл, утга зохиол болон түүх судлах хүрээлэнгээс аман зохиолын хээрийн шинжилгээгээр сурвалжлан цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээ 1961 оноос эхлэн “Халимаг тууль” гэсэн дөрвөн боть ном халимаг кирил үсгээр хэвлүүлсэн байдаг. “Халимаг тууль” (нэг) [42] гэсэн 1961 оны эмхэтгэлд нийт 62 үлгэр орсон бөгөөд үүнд 15 баатарлаг үлгэр, 18 шидэт үлгэр, 19 аж байдлын үлгэр, 8 амьтны үлгэр болон нэг домог орсон байна. Тус эмхэтгэлд орсон 62 үлгэрийн доторх 31 үлгэр нь 1941 онд хэвлэгдсэн “Халимаг Фольклор” гэсэн номоос шууд аван ашигласан бөгөөд үлдсэн 20 үлгэрийг нь И.И.Поповын 1890-1893 онд Тэн голын халимагуудаас цуглуулан тэмдэглэсэн гар бичмэлийн материал болон бусад зүйлээс авч хэрэглэжээ.

1979 онд Е.А.Бужалов “Халимаг тууль” [43] гэдэг номыг эмхэтгэж Элстэй хотод хэвлүүлсэн юм. Тус эмхэтгэлд 51 үлгэр орсон бөгөөд түүний 45 үлгэрийг нь “Халимаг тууль”

(нэг) гэх 1961 онд хэвлэгдсэн номоос аван хэвлэжээ. 1961 болон 1979 онд хэвлэгдсэн “Халимаг туульс” эмхэтгэлийн нэг дутагдалтай зүйл нь гэвэл, 1941 онд хэвлэгдсэн “Халимаг фольклор” гэсэн эмхэтгэлээс 31 үлгэрийг авч хэрэглэхдээ, уул хэвлэгдсэн номны хойно дагалдсан үлгэр бүхнийг хэлэгч, тэмдэглэгч, тэдний газар орон, нас, овог аймаг, хэлж тэмдэглэсэн он сар зэргийг орхиж хэвлэсэн явдал болой.

“Халимаг туульс” гэсэн 1979 онд хэвлэгдсэн эмхэтгэл нь 1990 онд тод үсгээр “Халимаг туульс” [44] гэх нэрээр Шинжааны Ардын хэвлэлийн хорооноос хэвлэжээ.

1968 онд Халимагийн хэл, утга зохиол болон түүх судлах хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан эрдэмтэн Бямбын Шуураа (Бембэн Шуура)-аас 1964 он болон 1965 оны өвлөөр хэлмэрч Манжийн Санж гэдэг авъяастай сайн үлгэрчээс тэмдэглэж авсан үлгэрүүдээ “Халимаг туульс” (хоёр) [45] гэх нэрээр Элстэй хотод халимаг кирил үсгээр хэвлүүлсэн юм. Тус үлгэрийн нэг онцлог гэвэл, нэг үлгэрчийн хэлсэн олон үлгэрийг нэг эмхэтгэлд оруулан хэвлэсэн явдал болно. Тус эмхэтгэлд нийт 68 үлгэр орсон байх бөгөөд үүнд баатарлаг үлгэр 8, шидэт үлгэр 24, амьтны үлгэр 3, домог 10 байхаас гадна “Жангар”-ын гурван үлгэр болон “Тэсэр”-ийн хоёр үлгэр оржээ. Хэлмэрч Манжийн Санж зөвхөн аман үлгэр хэлэхээр барахгүй аман зохиолын бусад төрөл зүйлийг ч сайн мэддэг хүн байсан байна. Тухайлбал, эрдэмтэн Номынханы Цэрэндорж (Номинхана Церндорж)-оос 1962 онд Манжийн Санжаар 70 хэдэн уртын дуу дуулуулж авсан байна. Манжийн Санжийн хэлсэн бусад үлгэр домгууд нь ч өөр өөр сонин сэтгүүл болон ном дэвтэрт мөн олон хэвлэгдсэн байна.

Халимаг хэл, утга зохиол болон түүх судлах хүрээлэнгийн эрдэмтэн Н.Н.Мусов, Б.Б.Оконов болон Е.Д.Мучкиноваас эрдэмтэн судлаачдын урьд өмнө үлгэрч нараас тэмдэглэж авсан үлгэрүүдээс эмхэтгэж “Халимаг туульс” (гурав) [46] гэдэг эмхэтгэлийг 1972 онд халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн байна. Тус эмхэтгэлд нь нийт 38 үлгэр орсон бөгөөд эмхэтгэгч нараас энэхүү үлгэрүүдээ:

- Аман үгийн хуучны туульс (энэ нь домог гэсэн утгаар хэрэглэгджээ)
- Баатарлаг туульс
- Хувилгаантай туульс (шидэт үлгэр гэсэн утгатай)
- Байдал жаргалын туульс (аж байдлын үлгэр гэсэн утгатай)

хэмээн дөрвөн төрөл зүйлд хуваасан байна. Энэ эмхэтгэл нь таван баатарлаг үлгэр, 18 шидэт үлгэр, зургаан аж байдлын үлгэр, найман домог болон “Тэсэр”-ийн нэг үлгэр орсон байна. Тус эмхэтгэлийн нэг онцлог гэвэл, үлгэр бүхний хойно нь хэлсэн хүний нэр, газар орон болон тэмдэглэгчийг дурдам өгсөн байна.

1974 онд эрдэмтэн П.Ц.Биткеев, З.Б.Улюмжиев нар эрдэмтэн судлаачаас 1962, 1967, 1968 онд Халимаг улсын нутагт явуулсан халимаг хэл, аман зохиолын тухай гурван удаагийн хээрийн шинжилгээний олдвороосоо 52 аман үлгэрийг сонгон “Халимаг туульс” (дөрөв) [47] гэсэн эмхэтгэлийг хэвлүүлсэн билээ. Эмхэтгэн хэвлүүлэгчээс 52 үлгэрээ:

- Шидэт туульс
- Баатарлаг туульс
- Байдал жаргалын болон хохирлогч туульс (аж байдлын үлгэр гэсэн утгатай)
- Туужлагч үлгэр, аман үг (энд домгууд багтсан байна)

гэж дөрвөн төрөл зүйлд хуваасан бөгөөд үүнд нь дөрвөн баатарлаг үлгэр, 16 шидэт үлгэр, 15 аж байдлын үлгэр, 15 домог болон нэг “Тэсэр”-ийн үлгэр орсон байна. Үлгэр болгоны хэлэгч, газар орон, жил нас, цуглуулсан он жилийг нь эмхэтгэгч нараас эмхэтгэлийн хойно дагалдуулж өгсөн нь тус эмхэтгэлийн үнэ цэнийг улам дээшлүүлж өгсөн байна.

Эрдэмтэн судлаач нар XVIII зуунаас эхлэн ойрад халимагийн аман үлгэрийг эмхэтгэж хэвлүүлэхдээ олон үлгэрч нарын хэлсэн үлгэрийг нэг эмхэтгэлд оруулан хэвлэдэг байсан бол харин 1960 онд Буринаан Муутларын нэг үлгэрчийн хэлсэн 12 үлгэр бүхий “Сэтгэлийн хүүр” хэвлэгдсэнээс аван ганц үлгэрчийн ярьсан үлгэрийн эмхэтгэлийг удаа дараалан хэвлэх болсон байна. Тухайлбал, “Халимаг туульс” (хоёр, 1968 он), “Саглар ээжийн туульс” (1989 он), “Алтан зүүн тэмнэ” (1995 он), “Буутаан Санжийн туульс” (2008 он), “Алтан цээжтэй хэлмэрч Боктаан Шания” (2010 он), “Т.С.Тягиновагийн аман уран үгийн хөрөнгөөс” (2011) гэх мэтийн олон ном эмхэтгэлийг дурдаж болох юм. Ийм ганц хүний хэлсэн үлгэрийг ном дэвтэр, эмхэтгэл болгож удаа дараалан хэвлэсэн явдал өөр бусад монгол газар оронд тун ч ховор хэмээн хэлж болно. Энэ нь мөн ч Халимагийн аман үлгэрийн нэг онцлог гэлтэй.

Нэг үлгэрч туульчийн хэлсэн олон үлгэр туульсийг нэг эмхэтгэлд оруулах, нэг үлгэрч буюу туульчийн хэлж хайлдаг үлгэр туулийг олон жил удаа дараалан дахин дахин тэмдэглэж хэвлүүлэх, мөн нэг газар орон, нэг овог аймаг, нэг улс, нэг үндэстэн буюу бусад үндэстэн ястан, улс орны нэг үлгэр туулийн олон зүйлийн хувилбарыг цуглуулж эмхэтгэж хэвлүүлэх нь аман зохиолын судлалд асар чухал ач холбогдол бүхий үйл ажиллагаа болох ёстой.

1975 онд эрдэмтэн Очирын Уташ, Чимэдийн Александраас дунд сургуулийн сурагчдад зориулан “Төрсөн (Төрсөн) литератур” [48] (өөрийн үндэстний уран зохиол, төрөлх уран зохиол гэсэн утга бүхий үг) гэсэн халимагийн аман зохиолын эмхэтгэлийг Элстэй хотод халимаг кирил үсгээр хэвлүүлжээ. Эмхэтгэлээ “Үлгэрүүд” (зүйр цэцэн үг гэсэн утга бүхий үг), “Тэжиг үг”, Тайлбартай туульс” (оньсого гэсэн утга бүхий үг), “Туульс” (явган үлгэр гэсэн утга бүхий үг), “Жангар” гэж таван төрөлд хуваасан байна. “Жангар”-ын бүлэгт нь хоёр бүлэг “Жангар” оржээ. Туульсын бүлэгт нь есөн явган үлгэр орсон байна.

1989 онд Халимагийн соёл, түүх шинжилгээний хүрээлэнгийн аман зохиол судлаач, эрдэмтэн Т.Г.Боржанова Халимагийн Элстэй хотод халимаг кирил үсгээр “Саглар ээжийн туульс” [49] гэсэн аман үлгэрийн эмхэтгэлээ хэвлүүлсэн юм. Тус эмхэтгэлд нийт 10 үлгэр орсон бөгөөд үүнд нь хоёр домог үлгэр, гурван амьтны үлгэр, дөрвөн аж байдлын үлгэр болон нэг шидэт үлгэр орсон байна. Т.Г.Боржановагаас эмхэтгэлд орж буй аман үлгэрээ Саглар гэдэг эмэгтэй үлгэрчээс тэмдэглэж авсан байна. Тус үлгэрчийн нэгэн онцлог гэвэл, хэлсэн 10 үлгэрийнхээ нэг хэсэг үлгэрийг нь шүлэглэн хэлсэн байдаг.

Халимагийн Соёл тууж шинжилгээний хүрээлэнгийн аман зохиол судлаач, эрдэмтэн Б.Б.Оконов “Бяцхануудын аман үгийн билгийн антологи” [50] гэсэн эмхэтгэлээ 1990 онд халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлжээ. Тус эмхэтгэлийг голдуу багачууд хүүхдэд зориулсан байдаг. Энэхүү эмхэтгэлд нь нэг бүлэг “Жангар”, долоон аман үлгэрээс гадна бас оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, ерөөл болон хүүхдүүд наадаж тоглохдоо хоорондоо хэлдэг зүйл бүрийн аман шүлгүүдийг багтаасан байна.

Жангар судлаач нэрт эрдэмтэн Кичгэйн Төлэй (Кичгэ Төлэ) болон Бямбын Гучаа (Бембэн Гуча)-аас 1990 онд сургуулийн сурагчдад зориулан аман зохиолын эмхэтгэл болох “Төрөсхөн литератур” (төрөлх манай уран зохиол, манай үндэстний уран зохиол гэсэн утга бүхий үг) [51] номыг 1990 онд халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн байна. Тус эмхэтгэлд есөн явган үлгэр, хэдэн арван зүйр цэцэн үг болон оньсого орсон байна. Мөн түүнчлэн Оросын алдарт шүлэгч А.С.Пушкины аман үлгэрийн маягаар зохиосон халимаг сэдэвт зохиол “Орос Гэлэнгийн болон түүний зарц Балданы туск (туск - тухай, холбогдол бүхий гэсэн утгатай үг) тууль” гэсэн зүйлс оржээ.

1992 онд Муутаан Инжэй (Муутан Инжэ)-ээс “Шар Богшаадай” [52] гэсэн аман үлгэрийн эмхэтгэлээ халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн байна. Энэхүү эмхэтгэлд нь долоон аман үлгэр оржээ.

1994 онд эрдэмтэн Калян Александр “Хэл өргөжүүлэгний дэвтэр” [53] гэсэн аман зохиолын эмхэтгэлийг Элстэй хотод халимаг кирил үсгээр хэвлүүлжээ. Эмхэтгэл нь гол төлөв дунд сургуулийн сурагчид уншихад зориулсан байна. Гэхдээ энэхүү эмхэтгэл нь Ойрад, Халимагийн аман зохиолын маш олон төрлийг бүгдийг нь хамарсан тун ч сайн эмхэтгэл болсон хэмээн хэлж болох юм. Тус эмхэтгэлээ эмхэтгэгчээс *Нэг*, үлгэрүүд. *Хоёр*, цэцэн үг. *Гурав*, ерөөлүүд. *Дөрөв*, олны дуун. *Тав*, хэмээлгэн. *Зургаа*, ут туулиуд. *Долоо*, тайлбартай туулиуд. *Найм*, гуравтас [54]. *Ес*, магтаалууд. *Арав*, “Жангар”-аас гэсэн 10 их төрөл хуваасан байна. Үлгэрүүд (зүйр цэцэн үг гэсэн утга бүхий үг)-ийн төрөлд нь 159 үлгэр бий. Цэцэн үгийн төрөлд нь 81 цэцэн үг бий. Ерөөлийн төрөлд нь 31 ерөөл оржээ. Олны дуун (олны дуунууд гэсэн гэсэн утга бүхий үг) гэсэн төрлөө дотор нь бас туужийн дуу (түүхийн дуунууд гэсэн утга бүхий үг), авъяасны болон хүч хөлсний дуун, дурны тусах дуу (янаг амрагийн дуунууд гэсэн утга бүхий үг), гэр мал болон өрх бүлийн, байдал жаргалын дуу (зан үйлийн холбогдол бүхий дуунууд гэсэн утга бүхий үг) хэмээн дөрвөн зүйлд хуваасан бөгөөд нийт 29 дуу орсон байна. Хэмээлгэнд нь 12 хэмээлгэн оржээ. Ут туулиуд (явган үлгэр гэсэн утга бүхий үг)-д нь арван ут (урт) тууль оржээ. Тайлбартай туулиуд (оньсого гэсэн утга бүхий үг)-ын төрөлд нь 89 тайлбартай тууль оржээ. Гуравтас (ертөнцийн гурав гэсэн утга бүхий үг, бас орчлонгийн гуравтас ч гэж хэлнэ)-ын төрөлд нь есөн гуравтас бий. Магтаалын төрөлд нь 18 магтаал оржээ. Домгийн төрөлд нь хоёр домог бий. “Жангар”-ын төрөлд нь дөрвөн бүлэг “Жангар” орсон байна. Мөн бүлэг бүрийн хойно нь үгсийн тайлбарыг үйлдэж өгсөн байна.

“Хичээл хойно уншлаганы дэвтэр-Халимаг улсын аман зөөр” [55] гэсэн номыг эрдэмтэн Мөнхийн Мария, Онтаан Зоя нар 1994 онд халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлжээ. Тус эмхэтгэлийг сургуулийн сурагчдад зориулан хэвлүүлсэн байна. Эмхэтгэлээ найман төрөлд хуваажээ. *Нэг*, бяцхануудад нааддгийн шүлэгнүүд. *Хоёр*, шинжис. *Гурав*, шаваашнууд. *Дөрөв*, тайлбартай туулиуд. *Тав*, үлгэрүүд. *Зургаа*, орчлонгийн гуравтас. *Долоо*, ерөөлүүд. *Найм*, улсын туулиуд. *Ут* туулиуд (явган үлгэрүүд)-ийн бүлэгт нь 31 ут тууль (явган үлгэр) орсон бөгөөд түүний дотроос 15 нь халимаг тууль, 16 нь монгол, буриад, орос, орчон, молдав зэрэг олон улс үндэстний туульс орсон байна.

1995 онд Элстэй хотод халимаг кирил үсгээр “Алтан зүүн тэмнэ” [56] гэсэн аман үлгэрийн эмхэтгэл хэвлэгдсэн юм. Тус эмхэтгэлд найман баатарлаг үлгэр, 16 шидэт үлгэр, хоёр аж байдлын үлгэр, нэг домог үлгэр болон “Гэсэр”-ийн хоёр үлгэр оржээ. Энэхүү 29 үлгэрийг Лийжийн Хөхөлдэйгийн Эрэнжэйн (Лижин Көклдэнэ Эрнжэн)-ээс өөрийн мэддэг үлгэрээ бичиж 1992 онд Халимагийн хэвлэлийн хороонд өгсөн байна. Лийжийн Хөхөлдэйгийн Эрэнжэйн бол 1930 онд Сталинград мужид төрж өссөн хүн юм. Тэр үлгэрүүдээ ээжээсээ сурсан байна. Түүний ээж нь Лийжиева Дулаш Коротаевна гэдэг хүн байсан бөгөөд тэрээр маш олон аман үлгэр хэлж чадахаар үл баран “Жангар”-аас ч арван гурав дөрвөн бүлэг хэлж хайлдаг хүн байсан байжээ. Лийжийн Хөхөлдэйгийн Эрэнжэйн хэлэхдээ “...*Бичсэн туулиуд болон “Гэсэр богдын тууж”-ийн тасархайс* (тасархайнууд, энэ нь “Гэсэр”-ийн зарим нэгэн бүлэг гэсэн утгатай)-г би эхээс даслаа би. Миний эх минь болохул “Жангар”-ын арван гурав дөрвөн бүлгүүд... цээжээр хэлдэг билээ. Дахиад тоогүй, далай олон (маш арвин олон гэсэн утгатай) туулиуд хэлдэг билээ... Миний эх далай тууль болон “Гэсэр богдын тууж”-ийн тасархайс, “Жангар”-ын бүлгүүдийг ахаасаа дассан (сурсан) байжээ. Тэр цагт энэ цаглай адил радио, телевизор, клуб, кино гэдэг юман үгүй байжээ. Эхийн минь ах асхан (орой) болгон хотондоо (айл саахалтдаа) нэг нэгэндээ одоод, найр наадам хийгээд, тууль, “Жангар” хэлэлдээд, сонсоод, дасаад явдаг байжээ. Эхийн эх эцэг нь тууль, “Жангар” хэлдэг байжээ, миний эцэг сургуульгүй (соёлгүй) хар хөдөлмөшч (хар ажил хийдэг хүн) хүн билээ. 1930-дагч жилүүдэд Колхоз (хамтрал)-д хөдөлмөш (хөдөлмөр) хийдэг билээ. Миний эцгийн үүр дүн улс (найз нөхөд нар) эцгээс минь сураад, хааяа хааяа

(заримдаа) цуглараад нэгжгээд шилээ хавтгалсан (өвөрлөсөн) ирцгээдэг билээ. Миний эх тамхи татдаггүй билээ, зуг (зөвхөн) амандаа аваад жажилдаг, архи уудаггүй билээ. Миний эцэгт тууль, “Жангар” сонсохоор ирсэн гийч нар тамхи папирос, заты бэлэгтэй ирцгээдэг байсан юм. Туулиуд, “Жангар” сонсоод, ханаад баярлаад харьцаадаг билээ. Эх сургуульгүй (соёлгүй), зуг (зөвхөн) буквари (цагаан толгой) уншдаг... Лийжийн Эрэнжэйний эх нь амьтанд хэлж өгдөг аман үгийн зөөрийг өөрийн ах Хожуоров Төлжэй Коротаевичээс дасч авсан юм чиг...” [57] хэмээн өөрийн үлгэр туулиа сурсан өнгөрөлт болон аав ээж, төрөл садныхаа байдлыг энэ мэт нарийн танилцуулсан байна. Мөн түүнчлэн, үлгэрчээс түүний эхийнх нь хэлдэг үлгэр тууль болон “Жангар”-ын бүлгүүдийг нь тэр газрын дарга 1935, 1936 оноор бичигтэй хүнээр тэмдэглүүлж үлдээх зорилготой байсан боловч тухайн үед тэрхүү нутаг нь Сталинград мужид харъяалагдах болсон ба удалгүй Дэлхийн II дайн үүссэн зэрэг олон шалтгаанаас болж энэхүү явдал нь биелэгдэлгүй хоцорсон харамсалтай явдлын тухай ярьсан байна. Эдгээр зүйлс нь ч тухайн цагийн тэр нутгийн аман зохиол болон үлгэрчийг судлахад үнэтэй ховор материал болон үлдсэн байна. Мөн хэвлэгчээс хэлэхдээ, үлгэрчийн хэвлэлд өгсөн аман үлгэрийг нь нэг ч үгэнд нь засалт хийлгүй хэвлэснээ дурджээ. Тус эмхэтгэлд урьд өмнө хэвлэгдээгүй маш олон үлгэр орсон нь тун сонирхолтой.

Халимагийн ардын аман зохиолыг хөгшдөөс цээжлэн өвлөх, цуглуулах, эмхэтгэх, орчуулах, хэвлүүлэх ажил үйлст Халимагийн зохиолчдоос бага бус ажил хөдөлмөр хийж ирсэн билээ. Түүний нэг нь Халимагийн алдарт зохиолч Калян Санж болох юм. Калян Санж хар багаасаа өөрийн үндэстнийхээ аман зохиол болон соёлдоо тун ч хайртай хүн байсан билээ. Тэрээр бага хүүхэд байснаасаа аваад өвгөд хөгшдийн хэлдэг зүйл бүрийн аман зохиолыг нэлээд олон цээжилснээр үл барам мөн тэмдэглэж ирсэн байв. Тэрээр өөрийн цээжилсэн зүйлсээ хүнд хэлж байснаар барахгүй мөн тэмдэглэж сонин сэтгүүлд ч нэлээд олон нийтлүүлж ирсэн билээ. 2005 онд Халимагийн хэвлэлийн хорооноос халимаг кирил үсгээр “Тээгийн булаг” [58] гэсэн ном Элстэй хотод хэвлүүлсэн юм. Тус номын зохиогч нь алдарт зохиолч Калян Санж болох юм. Энэхүү ном нь дээд болон доод гэсэн хоёр ангиас бүрэлдсэн. Дээд анги нь Калян Санжийн зохион бүтээсэн зохиолууд, доод анги нь Калян Санжийн өөрөө мэддэг болон бусдаас тэмдэглэж авсан аман зохиолын зүйл бүрийн хэрэглэгдэхүүн болно. Энэхүү аман зохиолын эмхэтгэлд “Шастир”, “Биеэ буулилан” (биеэ магтсан зүйлс гэсэн утга бүхий үг), “Магтаал”, “Ерөөл” “Муужруулган” (бусдыг муу хэлсэн зүйл гэсэн утга бүхий үг) “Хараал”, “Шаваашнууд болон домборуудад хэлэгддэг дуун”, “Сөнгийн дуу”, “Саатуулганы дуу” (бүүвэйн дуу гэсэн утга бүхий үг) гэсэн аман зохиолын олон төрөл зүйл орсноос гадна бас нэлээд олон домог үлгэр, домог, явган үлгэр болон ардын дуу орсон байна.

2008 онд Халимаг соёл түүхийг судлах хүрээлэнгийн эрдэмтэн Б.Х.Борлыковагаас нэртэй үлгэрч Буутаан Санжийн хэлсэн 33 үлгэр бүхий “Буутаан Санжийн туульс” [59] гэсэн үлгэрийн эмхэтгэлийг халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн байна. Эмхэтгэгчээс тус эмхэтгэлд орсон үлгэрүүдээ ан адгуусны туульс, шидэт туульс, баатарлаг туульс, байцын туульс (аж байдлын үлгэр гэсэн утгатай), хэлбэрүүд болон ахар шог гэж таван төрөл зүйлд хуваасан байна. Тус эмхэтгэлд гурван баатарлаг үлгэр, 13 шидэт үлгэр, есөн аж байдлын үлгэр, хоёр амьтны үлгэр, таван домог болон нэг “Тэсэр”-ийн үлгэр орсон байна. Тус эмхэтгэлд орсон үлгэрүүд нь үлгэрчээс голдуу 1974 онд тэмдэглэж авсан зүйлс байх ба мөн цөөхөн хэдэн үлгэрийг нь 1971 болон 1978 онд тэмдэглэж авсан байна. Тус эмхэтгэлд нь оршлоос гадна, эмхэтгэлийн хойно нь нэр үгсийн хэлхээс, халимаг үгсийн орос орчуулга, эмхэтгэлд орсон үлгэр болгоныг тэмдэглэж авсан он жил өдөр сар, тэмдэглэгч, хадгалагдаж байгаа архивын дугаар зэргийг маш нарийнаар тэмдэглэсний хамт үлгэрчийн төрөл садан, найз нөхөд болон

эрдэмтэн судлаачид нараас үлгэрч Буутаан Санжийн тухай бичсэн элдэв зүйлийн дурсамж болон өгүүллүүдийг хавсаргасан байна.

2009 онд Халимагийн соёл, түүх судлах хүрээлэнгийн аман зохиол судлаач, эрдэмтэн Т.Г.Басанговагаас халимагийн 17 аман үлгэрийг халимаг кирил үсгээр “Халимагийн хүүхдийн аман зохиол” [60] гэсэн нэрээр Элстэй хотод хэвлүүлсэн байна. Тус эмхэтгэлд нь орж буй 17 аман үлгэрийн олонх нь амьтны үлгэр юм. Үүнд амьтны үлгэр 11, шидэт үлгэр 1, хошин шог үлгэр 5 орсон байна.

2009 онд 130 хэдэн үлгэрийг багтаасан том эмхэтгэлийг Элстэй хотод “Халимаг туульс” [61] гэх нэрээр халимаг кирил үсгээр В.Д.Бадмаева хэвлүүлсэн байна. Эмхэтгэн хэвлүүлэгчээс энэхүү эмхэтгэлд орсон аман үлгэрээ илбэтэй туульс (шидэт үлгэр гэсэн утгатай), баатарлаг туульс, байцын болон дамбарлалганы тусхи туульс (аж байдлын тухай үлгэр гэсэн утгатай), ан агуусны тусхи туульс (энэ нь ан адуусны тухай аман үлгэр гэсэн утгатай) хэмээн дөрвөн төрөлд хуваажээ. Тус эмхэтгэлд 16 баатарлаг үлгэр, 47 шидэт үлгэр, 22 аж байдлын үлгэрээс гадна дөрвөн баатарлаг туульс орсон байна. Энэ эмхэтгэлд орсон үлгэрүүд нь ерөнхийдөө урьд өмнө нь гарч өнгөрсөн ном хэвлэлүүдээс авч хэрэглэсэн байна. Гэхдээ эмхэтгэгчээс бусад ном эмхэтгэлээс авч хэрэглэхдээ хэрэглэсэн үлгэрүүдээ ямар номоос авсан, хэн хэлсэн, ямар хүн эмхэтгэсэн, аль хэвлэлийн газраас хэвлэгдсэн гэх мэтийн олон зүйлийг нь тодорхойлж өгсөнгүй юм. Энэ нь энэхүү эмхэтгэлийн дутагдалтай тал буюу харамсалтай зүйл нь болсон байна.

2010 онд Халимагийн соёл, түүх судлах хүрээлэнгийн эрдэмтэн доктор Б.Б.Манжиев (Б.Б.Манджиев, халимаг нэр нь Манжийн Баяртай)-аас “Алтан цээжтэй хэлмэрч Боктаан Шаня” [62] гэсэн ганц хүний хэлсэн аман үлгэрийн эмхэтгэлийг халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн билээ. Эрдэмтэн Манжийн Баяртайн тус эмхэтгэлд оруулсан 45 үлгэр нь хошууд үлгэрч Боктаан Шанягаас 2001-2008 оны хооронд бичлэг хийж тэмдэглэж авсан үлгэрүүд юм. Эмхэтгэгчээс тус эмхэтгэлд орж бүхий үлгэрүүдээ домогууд болон туужис (энэ нь домог үлгэр болон домог гэсэн утгаар хэрэглэжээ), туульс (явган үлгэр гэсэн утгатай) хэмээн хоёр ангилжээ. Туульсын ангиа дотор нь мөн ан адгуусны тусхи туульс, шидэт туульс, баатарлаг туульс, байцын туульс гэж дөрвөн төрөл зүйлд хуваасан бөгөөд үүнд нэг домог үлгэр, 11 домог, гурван баатарлаг үлгэр, 25 аж байдлын үлгэр болон гурван амьтны үлгэр орсон байна. Тус эмхэтгэлд аман үлгэрүүдээс гадна бас шог болон худал, хошуудын дуу, зүйр цэцэн үгс, оньсого хийгээд бусад төрөл зүйл ч нэлээд орсон байна. Эмхэтгэгчээс тус эмхэтгэлдээ үлгэрч Боктаан Шанягийн тухай судалсан урт оршил бичсэнээс гадна үлгэрүүдийнхээ хойно үгсийн тайлбар, зүүлт, нэрсийн хэлхээ зэргийг хавсаргажээ.

2011 онд “Т.С.Тягиновагийн аман уран үгийн хөрөнгөөс” [63] гэсэн 37 үлгэр бүхий нэг үлгэрчийн хэлсэн үлгэрийн эмхэтгэлийг Элстэй хотод халимаг кирил үсгээр хэвлүүлсэн билээ. Тус эмхэтгэлийг Халимагийн соёл, түүх судлах хүрээлэнгийн эрдэмтэн доктор Б.Б.Горяева хэвлэлд бэлтгэсэн бөгөөд үүнд нь зургаан шидэт үлгэр, 17 аж байдлын үлгэр, гурван домог үлгэр, хоёр домог, зургаан амьтны үлгэр болон “Жангар”-ын нэг үлгэр орсон байна. Эмхэтгэгчээс эмхэтгэлд орсон аман үлгэрээ домогууд болон туужис хийгээд явган үлгэр хэмээн хоёр анги хуваажээ. Явган үлгэрээ мөн дотор нь ан адгуусны тусхи туульс, шидэт туульс, байцын туульс гэж гурван төрөл зүйлд хуваажээ. Эмхэтгэлд аман үлгэрээс гадна дуу, зүйр цэцэн үгс, оньсого, зан үйл зэрэг олон төрлийн зүйлс орсон байна. Эмхэтгэгчээс эмхэтгэлийн хойно нь үгсийн тайлбар, нэр үгсийн хэлхээс, үлгэрчийн сурвалжлага болон үлгэрчийн тухай судалсан судалгааны хоёр өгүүллийг хавсаргасан байна.

“Хулгана болон тэмээн-ан агуурсны тусхи туульс” [64] гэсэн 34 амьтны үлгэр бүхий аман үлгэрийн эмхэтгэлийг 2012 онд халимаг кирил үсгээр Элстэй хотод Б.Д.Бадмаеваас хэвлүүлжээ. Тус эмхэтгэл нь Халимагийн анхны амьтны үлгэрийн эмхэтгэл болсон юм.

2014 онд И.М.Болдиреваас “Гэрэлтсэн сувсан- Б.М.Санжиеваан бичүүлж авсан аман уран үгийн хөрөнгөөс” [65] гэсэн номыг халимаг кирил үсгээр Элстэй хотод хэвлүүлсэн юм. Эмхэтгэлд орж бүхий аман зохиолыг Б.М.Санжиева 1972-1974 оны хооронд халимаг үлгэрч нараас тэмдэглэж үлдээсэн зүйлс болно. Эмхэтгэн хэвлүүлэгч И.М.Болдиреваас тус эмхэтгэлд орж бүхий зүйлсээ Нэг, домог болон туужис. Хоёр, ут туульс. Гурав, хэмээлгэн. Дөрөв, далын шинж. Тав, шаваашнууд. Зургаа, хуучин цагийн дуу. Долоо, үлгэрүүд болон цэцэн үгүүд. Найм, тайлбартай туульс. Ес, гарын хуруудын хүүндвэр. Арав, ерөөл гэж арван ангид хуваажээ. Үлгэр болон цэцэн үгүүдийн ангид нь 764 зүйр цэцэн үг, тайлбартай туульс (оньсогууд)-ын ангид нь 47 тайлбартай тууль, ерөөлийн ангид нь 45 ерөөл оржээ. Дуунд нь 98 дуу орсон бөгөөд түүгээ шастир дуу (дуунууд), ут дуу (урт дуунууд), халимаг хүүхэд улсын тусхи дуу (энэ нь халимагийн эмэгтэй хүмүүсийн тухай дуунууд гэсэн утга бүхий үгс юм), Советийн цагийн дуу хэмээн хуваасан байна. Ут туульс гэж нэрлэдэг явган үлгэрээ дотор нь баатарлаг туульс, шидэт туульс, байцын туульс (аж байдлын үлгэр гэсэн утгатай) гэж хуваасан бөгөөд үүнд нь гурван баатарлаг үлгэр, зургаан шидэт үлгэр, зургаан аж байдлын үлгэр орсон байна. Домог болон туужис (домог үлгэр болон домог гэсэн утгатай)-ын ангид нь нэг домог үлгэр болон 11 домог оржээ. Мөн түүнчлэн зан үйлийн холбогдол бүхий зүйлс ч нэлээд орсон бий. Эмхэтгэн хэвлүүлэгчээс тус эмхэтгэлдээ Б.М.Санжиевагийн тухай бичсэн урт оршлоос гадна эмхэтгэлийн хойно нь үлгэрч нарын танилцуулга, тэдний нэр овог, хэлсэн он жил сар өдөр, орон газар зэргийг маш нарийнаар танилцуулсны хамт нэр үгсийн хэлхээсийг үйлдэж өгсөн байна.

Эрдэмтэн судлаачид ойрад халимагийн аман үлгэр болон бусад аман зохиолын төрөл зүйлийг аль эртнээс цуглуулан тэмдэглэж олон ном дэвтэр, эмхэтгэлүүд хэвлүүлж ирсэн төдийгүй мөн сонин сэтгүүл дээр ч нийтэлсээр ирсэн билээ. Халимаг нутагт XX зууны эхнээс зүйл бүрийн сонин сэтгүүлүүд хэвлэгдэн олны хүртээл болсоор ирэв. Тухайлбал, “Ойрадын занги”, “Улаан Халимаг”, “Улаан тээг”, “Тангачийн занги”, “Тээгийн гэрэл”, “Лениний зам”, “Лениний ач нар”, “Улаан загасч”, “Халимаг үнэн”, “Зөвлөлтийн Халимаг тангач” гэх мэтийн сонинууд гарч байсан ба “Ойрадын занги”, “Халимаг коммунистын намын занги”, “Халимаг увласт”, “Ажлын ард”, “Улаан туг”, “Халимаг тээг”, “Манай хэлэн”, “Тээгийн гэрэл” гэх мэтийн сэтгүүл ч хэвлэгдэж иржээ. Түүнчлэн зарим нь одоо хүртэл мөн хэвлэгдсээр байгаа. Жишээлбэл, долоо хоногт зургаан дугаар хэвлэгдэх “Халимаг үнэн” сонин нь 1957 оноос одоо хүртэл хэвлэгдсээр байгаа бөгөөд “Тээгийн гэрэл” гэдэг утга зохиолын сэтгүүл нь 1957 оноос эдүгээ хүртэл мөн хэвлэгдсээр ирсэн билээ. Энэхүү олон сонин сэтгүүлд ч Халимагийн маш олон аман зохиолын эх хэрэглэгдэхүүн хэвлэгдэж ирэв. Үүний дотор нь мөн аман үлгэр ч олон бий.

Бас нэг дурдалгүй өнгөрч үл болох зүйл нь гэвэл, Халимагийн эрдэмтэн судлаачид болон багш нараас Халимагийн бага сургууль болон дунд сургуулийн сурагч нарт зориулан найруулсан утга зохиолын унших бичгүүд болно. Эртнээс аван хэвлэгдсэн утга зохиолын зүйл бүрийн унших бичигт нь аман зохиолын зүйлс зохих хувийг эзэлсэн байдаг. Эдгээр бичиг номуудад аман үлгэр олон хэвлэгдсэн байна.

Дүгнэж хэлэхэд, Халимагт XIX зууны дундаас халимаг хэлээр (тод үсэг, халимаг кирил үсэг, халимаг латин үсэг, зүйл бүрийн олон улсын галиг, орос маягийн эрдэм шинжилгээний галиг) эдүгээ болтол хэвлэгдсэн ном дэвтэр хийгээд эмхэтгэл их төлөв 30 хэдэн дэвтэр хэвлэгдсэн бөгөөд орос, герман болон бусад улс үндэстний хэлээр орчуулсан аман үлгэрийн ном эмхэтгэл

ч 30 хэдэн дэвтэр болсон байна. Орос болон бусад улс үндэстний хэлээр орчуулан хэвлэсэн номууд нь ерөнхийдөө халимаг хэлээр хэвлэгдсэн номоос орчуулагдсан бөгөөд агуулга нь ерөнхийдөө адил юм. XIX зууны дундаас аван халимаг хэлээр хэвлэгдсэн аман үлгэр (домог, домог үлгэр багтана)-үүд эдүгээ нэгэнт 1000 шахам байгаа юм. Яг давтагдахгүй нь 700 гаруй үлгэр байх бөгөөд үүний дотор 70 хэдэн баатарлаг үлгэр, 200 гаруй шидэт үлгэр, 200 гаруй аж байдлын үлгэр (жирийн үлгэр, хошин шог үлгэр багтана), 100 амьтны үлгэр, 150 шахам домог болон 20 хэдэн домог үлгэр бий.

Ойрад халимагуудын аман үлгэрийг эрдэмтэн судлаачдаас сурвалжлан цуглуулах, орчуулах, эмхэтгэн хэвлүүлэх ажил нь Монголын бусад овог аймаг, газар орноос тун ч эрт эхэлсэн бөгөөд тэмдэглэсэн эх хэрэглэгдэхүүнүүд нь ч тун оновчтой тэмдэглэгдсэн мөртөө үлгэрч туульчийн хэлж хайлсан зүйлсийг нь мөн тэр хэвээр нь ямар ч засалт оруулалгүйгээр хэвлэхээр тун ч чармайсан байна. Энэхүү зүйлс нь өнөөдөр манай хэл болон аман зохиолын судлалын ховор нандин зүйл болсоор байгаа билээ.

Зүүлт тайлбар

1. **И.Лепехин.** *Дневные записки путешествия поразным провинциям Российского государства 1768-69 гг.* Ч. 1. СПб., 1771.
2. [德]P. S. 帕拉斯著:《内陆亚洲厄鲁特历史资料》邵建东、刘迎胜译, 昆明:云南人民出版社, 2002年.
3. **B.Bergmann.** *Nomadische Streifereien unter den Kalmücken in Jahren 1802 und 1803.* Bd. 1-3. Riga. 1804; Bd. 4. Riga. 1805.
4. Манай улсын жангар судлагч эрдэмтдийн олонх нь Б.Бергманыг Герман улсын жуулчин хэмээн буруу бичсээр ирсэн бөгөөд эдүгээ ч мөн тэр хэвээр бичсээр байгаа. Мөн 1804-1805 онд хэвлэгдсэн “Жангар”-ыг Германы Рига хотод хэвлэсэн хэмээн бас л буруугаар тэмдэглэсээр буюу. Энэ мэт бичсэн зүйлс нь зүйл бүрийн ном дэвтэр болон Монголын утга зохиолын нэвтэрхий толинд ч байгаа билээ. Үнэндээ Б.Бергман бол Герман улсын хүн бус, харин Латви нутагтай герман хүн юм. Мөн Рига хот нь Германд байгаа бус, одоогийн Латви улсын нийслэл нь юм. Эрдэмтэн судлаачид судалгаа хийхдээ сайн анхаарахгүй бол инээдэмтэй зүйл олон гарч мэдэх юм. Эрдэм зохиолоо туурвихдаа та бүхэн сайн анхаарах болов уу!
5. *Убаиш Хун-тайджийн тууджи. Народная калмыцкая поэма Джангара и Сиддиту кюриин туули.* Изданная на калмыцком языке К.Ф.Голстунским. СПб., 1864.
Die Märchen des Siddhi-Kür. Kalmückischer Text mit deutscher Übersetzung herausgegeben von B.Jülg. Leipzig, 1866.
7. **Jülg B.** *Mongolische Märchen-Sammlung.* Die neun Marchen des Siddhi-Kür nach der ausführlicheren Redaction und die Geschichte des Ardschi-Bordschi Chan. Mongolisch mit deutscher Übersetzung und kritischen Anmerkungen. Innsbruck, 1868.
8. **Галсан Гомбоев.** *Шидди кур, собрание монгольских сказок.* Этнографический сборник. Издаваемый Рус. Географ. Общ. Вып. 6. СПб., 1864.
9. *Калмыцкие сказки.* Собранные Лером. М., 1873.
10. **Birtalan Agnes.** *Kalmyk Folklore and Folk Culture Mid-19th Century.* 2011.
11. Үлгэр - Энд зүйр цэцэн үгийг зааж буй. Ер Шинжааны ойрадууд болон ОХУ-д амьдарч байгаа халимаг хүмүүс зүйр цэцэн үгийг үлгэр буюу үлгэр үг хэмээн нэрлэдэг юм.

12. Тайллагатай тууль - Энд оньсогыг зааж буй. Тууль гэдэг үг ер нь Шинжааны ойрадууд болон ОХУ-ын халимаг хүмүүст хоёр зүйлийн утга буй. Нэг нь домог үлгэр болон домгийг багтаасан бүх үргэлжилсэн үгийн аман үлгэрийг нэрлэдэг. Нэн тодруулж хэлбэл ахар тууль, тайллагатай тууль, тайлбартай тууль гэж оньсогыг нэрлэдэг. Ут тууль гэж домог үлгэр, домгийг багтаасан үргэлжилсэн үгээр хэлэгдэх аман үлгэрүүдийг нэрлэдэг.
13. Ут тууль - Урт тууль. Энэ нь домог, домог үлгэрийг багтаасан үргэлжилсэн үгийн аман үлгэрийн ерөнхий нэрийдлэг юм. Нэн тодруулж хэлбэл, Шинжааны Алтайн Урианхай, Ховогсайрын торгууд, Тарвагатайн өөлд, Хүр Хар-Усны торгууд хүмүүс домог, домог үлгэрийг багтаасан үргэлжилсэн үгийн хэлбэр бүхий үлгэрүүдийг “түүх”, оньсогыг “тууль”, судар бичгээр бичигдсэнийг “тууж” хэмээн нэрлэдэг. Борталын цахар, Жингийн торгууд, Илийн Нялх, Монголхүрээ, Тэхэсийн өөлд, торгууд хүмүүс нь домог, домог үлгэрийг багтаасан үргэлжилсэн үгийн хэлбэр бүхий аман үлгэрийг “тууль” гэж, оньсогыг “оньсого” гэдэг байна. Баянголын 54 сум торгууд болон 10 сум хошууд хүмүүс домог, домог үлгэр, явган үлгэр болон “Жангар”-ыг бүгдийг нь жангар гэж нэрлэдэг юм.
14. Потанин Г.Н. *Очерки Северо-Западной Монголии*. СПб., Вып. 2. 1881, Вып. 4. 1883.
15. G.N. ボタ ニン著:《西北蒙古誌》(第二卷) 民俗、慣習編、东亚研究所譯、龙文书局、昭和二十年五月。
16. [苏联] 格·尼·波塔宁著:《蒙古纪行》吴吉康、吴立琚译、兰州:兰州大学出版社、2013年。
17. *Калмыцкая хрестоматия для чтения в старших классах калмыцких народных школ*. Сост. А.Позднеевым. 1-е изд. СПб., 1892; 2-е изд. СПб., 1907; 3-е изд. СПб., 1915.
18. Позднеев А.М. (ред.) *Джангар. Героическая поэма калмыков, с приложением вновь открытой и впервые издаваемой третьей главы, в оригинальном калмыцком тексте*. СПб., 1911.
19. Позднеев А.М. *Образцы народной литературы монгольских племен. Народные песни монголов*. Вып. 1. СПб., 1880.
20. *Калмыцкие народные сказки, собранные в Калмыцких степях Астраханской губернии и в подлинном калмыцком текст*. Изданные А.М.Позднеевым. СПб., 1886.
21. Позднеев А.М. *Калмыцкие сказки: Текст и перевод*. ЗВОРАО. Т. 3. СПб., 1889; Позднеев А.М. *Калмыцкие сказки: Текст и перевод*. ЗВОРАО. Т. 4. СПб., 1891; А.М.Позднеев. *Калмыцкие сказки: Текст и перевод*. ЗВОРАО. Т. 9. СПб., 1896.
22. *Калмыцкие народные сказки, собранные в калмыцких степях Астраханской губернии*. Изданные А.М.Позднеевым. СПб., 1892.
23. *Джангар. Национальная поэма в оригинальном тексте и русском переводе с примечаниями И.И.Попова*. 1892 г. Из фондов Архивного отдела УНКВД РО (13808)
24. *Загадки Донских калмык*. В подлинном тексте и переводе. Собрал и записал И.И.Попов. 1892. Из фондов Архивного Отдела УНКВД РО (13807).
25. *Пословицы и поговорки Донских калмык в оригинальном тексте и русском переводе*. Собраны и записаны И.И.Поповым. Азовото-Черноморское Краевое Архивное Управление. Ростов на Дону, 1892.
26. *Народные сказки Донских калмык (в русском переводе)*. Перевод с примечаниями И.И.Попова. 1890-1891 гг. Из фондов Архивного отдела УНКВД РО (13805).
27. *Народные сказки Донских калмык*. Том 2, часть 1. Собрал и записал И.И.Попов. 1892. Из фондов Архивного Отдела УНКВД РО (13810).
28. *Былевые сказания Донских калмык*. В оригинальном калмыцком тексте и русском переводе. Собрал и записал И.И.Попов. Том 1. часть 1. 1892. Из фондов Архивного Отдела УНКВД РО (13809).

29. *Сказки Донских калмыков*. Записал и перевил И.И.Попов. Ростов на Дону, 1938.
30. **Бадмаев А.** *Сборник калмыцких сказок*. Астрахань, 1899.
31. *Kalmückische Sprachproben I. Kalmückische Märchen*. 1-2. Ges. u. hrsg. von G.J.Ramstedt. Suomalais-Ugrilaisen Seuran Toimituksia=Mémoires de la Société Finno-Ougrienne. 27/1-2. Helsingfors 1909, 1919.
32. **Владимирцов Б.Я.** *Волшебный мертвец*. 1-е изд. М., 1923; 2-е изд. М., 1958.
33. *Үхсэн цогцны хувилгаан-Монгол ойрадын туульс*. Э.Г.Манжиев орос хэлнээс орчуулав. Халимаг улсын хэвлэлийн газар. Элстэй, 1962.
34. Манай улсын жангар судлагч олонх эрдэмтэд Ээлэйн Овлаан арван бүлэг “Жангар”-ыг цуглуулан тэмдэглэж, “Жангар”-ын нэр алдрыг дэлхий дахинд алдаршуулсан Халимагийн алдарт эрдэмтэн Очирын Номтыг Номтын Очир хэмээн тун ч буруугаар бичсээр ирсэн бөгөөд эдүгээ ч мөн буруугаар бичсэн хэвээрээ байгаа. Энэ нь яг аавыг нь хөвүүн болгож хөвүүнийг нь аав болгож байгаа явдал болой. Маш инээдэмтэй.Эрдэмтэн Очирын Номтыг халимагаар “Очра Номт” гэж, оросоор “Номто Очиров” гэж бичдэг юм. “Номто Очиров” хэмээн оросоор бичсэн зүйл нь болбоос Очир овогтой Номт гэсэн үг болохоос бус Номтын Очир гэсэн үг яасан ч биш ээ. Эрдэмтдээс хүсэх минь материалыг ашиглахдаа ашиглаж байгаа материалынхаа утга учрыг нь сайнаар ойлгосон суурь дээр зохиол бүтээлээ бичиж туурвихыг анхааралдаа авахыг хүсэж байнам.
35. *Тахь зул хааны үлдэл, тансаг Бумба хааны ач, Үзүн алдар хааны хөвүүн, үеийн өнчин Жангарын арван бүлэг*. В.Л.Котвич хэвлүүлэв. СПб., 1910.
36. *Мөнхийн дээж-аман уран үгийн зохиолууд*. Очирын Номт цуглуулан тэмдэглэв. Б.А.Бичеев эмхэтгэн хэвлүүлэв. Халимаг дэвтэр гаргаач. Элстэй, 2006.
37. *Хонх*. Халимаг дээж бичиг. Прага., 1925. 1926. 1927. 1927 1927.
38. *Калмыцкие сказки*. Ред., вступит. статья и коммент. И.Кравченко. Сталинград, 1936.
39. И.Кравченко. *Фольклор калмыцкого народа*. Народное творчество Калмыкии. Сталинград-Элиста. 1940.
40. *Халимаг фольклор*. Лэжиний Цэрэн, Шалварын Гарай эмхэтгэв. Элстэй, 1941.
41. *Сэтгэлийн хөөр*. Бурнайн Муутлаар хэлэв. Букшаан Бадам тэмдэглэв. Халимаг хэл утга зохиол болон түүх судлах хүрээлэнгийн Утга зохиол болон Аман зохиол судлах тасгаас хэвлүүлэв. Халимаг дэвтэр гаргаач. Элстэй, 1960.
42. *Халимаг туульс*. Нэгдэгч боть. Б.Сангажиева болон Л.Сангаев эмхэтгэв. Элстэй, 1961.
43. *Халимаг туульс*. Е.А.Бужаловоос эмхэтгэн хэвлүүлэв. Элстэй, 1979.
44. *Халимаг туульс*. Шинжааны Ардын хэвлэлийн хороо, 1990.
45. *Халимаг туульс*. Хоёрдогч боть. Манжийн Санж 1964 он болон 1965 оны өвөл хэлэв.Бямбын Шуураа тэмдэглэв. Элстэй, 1968.
46. *Халимаг туульс*. Гуравдагч боть. Н.Н.Мусова, Б.Б.Оконов болон Е.Д.Мучкинова эмхэтгэв. Элстэй, 1972.
47. *Халимаг туульс*. Дөрөвдүгээр боть. П.Ц.Биткеев, З.Б.Үлэмжиева эмхэтгэв. Элстэй, 1974.
48. *Төрхсөн литератур*. Очирын Уташ, Чимидийн Александр эмхэтгэн найруулав. Элстэй, 1975.
49. *Саглар ээжийн туульс*. Т.Г.Боржанова цуглуулан тэмдэглэв. Элстэй, 1989.
50. *Бяцхануудын аман үгийн билгийн антологи*. Б.Б.Оконов эмхэтгэв. Элстэй, 1990.
51. *Төрхсөн литератур*. Кичигийн Төлэй, Бямбын Гучаа эмхэтгэн найруулав. Элстэй, 1990.

52. Шар Богшаадай. Муутаан Инжэй цуглуулан эмхэтгэв. Элстэй, 1992.
53. Хэл өргөжүүлэгчийн дэвтэр. Калян Александр эмхэтгэн найруулав. Элстэй, 1994.
54. Гуравтас - Энэ нь "Ертөнцийн гурав"-ыг зааж буй. Мөн бас "Орчлонгийн гуравтас" гэж ч хэлдэг.
55. Хичээл хойно уншлаганы дэвтэр - Халимагийн аман зөөр. Мөнхийн Мария, Онтаан Зоя эмхэтгэн найруулав. Элстэй, 1994.
56. Алтан зүүн тэмнэ. Лийжийн Хөхөлдэйн Эрэнжэн хэлэв. Элстэй, 1995.
57. Алтан зүүн тэмнэ. Лийжийн Хөхөлдэйн Эрэнжэн хэлэв. Элстэй, 1995, х.3.
58. Тээгийн булан. Калян Санж. Элстэй, 2005.
59. Буутаан Санжийн туульс. Буутаан Санж хэлэв. Б.Х.Борлыкова эмхэтгэв. Элстэй, 2008.
60. Халимагийн хүүхдийн аман зохиол. Т.Г.Баасангова эмхэтгэв. Элстэй, 2009.
61. Халимаг туульс. В.Д.Бадмаева эмхэтгэв. Элстэй, 2009.
62. Алтан цээжтэй хэлмэрч. Боктаан Шаня хэлэв. Б.Б.Манжиева эмхэтгэв. Элстэй, 2010.
63. Т.С.Тягиновагийн аман уран үгийн хөрөнгөөс. Т.С.Тягинова хэлэв. Б.Б.Горяева эмхэтгэв. Элстэй, 2011.
64. Хулгана болон тэмээн - Ан агуурсны тусхи туульс. Б.Д.Бадмаева эмхэтгэв. Элстэй, 2012.
65. Гэрэлтсэн сувсан-Б.М.Санжиевагийн бичүүлж авсан аман уран үгийн хөрөнгөөс. Б.М.Санжиева цуглуулан тэмдэглэв. И.М.Болдирева эмхэтгэв. Элстэй, 2014.